

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234726

ХОВОГСАЙРЫН ТОРГУУДЫН УРТЫН ДУУН ДАХЬ МОРИНЫ
ЗҮСМИЙН БЭЛГЭДЭЛ

Н.Бадамцэцэг

Товчлол. Энэ өгүүлэлд би Ховогсайрын торгуудчуудын дуулдаг “Алиа цавьдар морин”, “Галзан хоо”, “Нарийхан сайхан хээр” гэсэн гурван уртын дууг шинжлэн судаллаа. Монгол морьтой холбоотой уртын дуунд морины зүсмийг бэлгэдэж, гүнзгий утга санааг илэрхийлдэг. Намжаагийн Намжав бол Шинжааны Ховогсайрын Торгуудчуудын дундаас төрсөн хосгүй дуучин бөгөөд түүний дуулсан уртын дуунууд одоог хүртэл хурим найранд дуулагдсаар байна. Намжавын дуулдаг дуунуудаас дээрх гурван дуу нь морины зүсмээр чухал гүн гүнзгий санааг илэрхийлсэн байдаг онцлогтой. “Алиа цавидар морь” дуунд төрийг “буурал” өнгөөр, буддизмыг “бумба” тамгаар бэлгэддэг. Мөн “хүрд” тамга, хүрээ хийдээр шашныг бэлгэдэн төр, шашныг хослуулсан дуу байдаг. Мөн “Галзан хоо” дуунд Хоо галзан морийг бэлгэдлийн дүр болгож, ээж болон, нутаг усаа санагалзсан хүний сэтгэлийг тод илэрхийлсэн байдаг. Гурав дахь дуу болох “Нарийхан сайхан хээр” дуу бол амрагийн дуу бөгөөд “хээр”, “хар”, “хүрэн” гэсэн гурван морины зүсмийн бэлгэдлээр алсад суугаа хайртай хүнээ санагалзах сэтгэлийг харуулжээ. Ерөнхийдөө эдгээр дуу нь найрын дуунууд бөгөөд бүх нийтийн амгалан тайван байдлыг бэлгэддэг.

Түлхүүр үг: Уртын дуу, морины зүсэм, бэлгэдэл, Ховогсайрын торгууд, Намжаагийн Намжав

Удиртгал

Алтайн нурууны баруун сугад нутаглаж байгаа Ховогсайрын монголчууд бол арван долоодугаар зууны далаад оноор Ижил мөрнөөс буцаж ирсэн торгуудууд, Цэвэгдоржийн үе хойч болно (Эрдэй, 2004:10). Энэ нутгийн хөрсөн дээр үе улиран амьдарч ирсэн ард түмний дотроос олон арван шүлэгч, жангарч, ерөөлч, дуучид төрөн гарч, Ховогсайр нутгийнхаа түүх соёлыг олны хүртээл болгосоор иржээ. Ховогсайрын торгууд ардын дуучдын нэгэн төлөөлөл болох Н.Намжав (1954-2001) хэдийгээр хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн ч түүний дуулсан дуунууд ард түмний сэтгэлд мөнхийн өв болон үлджээ. Судлаачид ардын дуучин Н.Намжавын дуулсан дуунуудыг цуглуулан эмхэтгэж, намтар түүхийнх нь тухай өмнө танилцуулж байсан ч түүний дууг утга агуулгын үүднээс задлан шинжилж байгаагүй учраас бид энэхүү сэдвийг сонгон авч үзэх болно.

“Монгол ардын дуунд мориор гол дүрслэгдэхүүн болгоогүй дуу тун ховор байдаг. Тэрчлэн монгол ардын дуунд би баатрын үйл хэрэг, хүсэл эрмэлзлийг

гол биелүүлэгч нь гарцаагүй морь байдаг” (Бат, Дангажав, 2018:292) тул Н.Намжавын дуулсан дуунуудаас “*Баруун Монгол ардын дууны уламжлал ба түүх соёлын хувьсал*” (2018) номд Д.Бат, Л.Дангажав нарын оруулан эмхэтгэсэн найман дуунаас морины зүсмээр утга агуулгаа баяжуулан бэлгэдсэн гурван дууг нь сонгож, задлан шинжиллээ.

Н.Намжавын зарим уран бүтээлийг толилуулсан хоёр эмхэтгэл байдаг. Тодруулбал,

- Судлаач Н.Зоригтын 2004 онд тод үсгээр бичин, Шинжааны Ардын хэвлэлийн хороонд хэвлүүлсэн “*Ховогсайр монгол ардын аман зохиолын дээж*” номд Ховогсайрын торгууд ардын дуучин Н.Намжавын “Алиа цавьдар морь” зэрэг найман дуу хэвлэгджээ.

- Эрдэмтэн У.Эрдэйгийн эмхэтгэн 2004 онд Шинжааны Ардын хэвлэлийн хороонд хэвлүүлсэн “*Тив алслан зүүнд буцсан Торгуудчууд*” номд Ховогсайрын торгууд ардын дуучин Н.Намжавын тухай дурдсан байдаг. Мөн Шинжааны ардын радио хороонд түүний 30 гаруй дуу нь бичлэг хэлбэрээр хадгалагдаж байна.

Тус бичвэрт Н.Намжавын дуулсан дууны яруу найргийг задлан шинжилж, утга агуулгаар нь төрөл сэдэв, агуулга, уран сайхны онцлогийг тайлан тайлбарлаж, нэгтгэн дүгнэв. Мөн судлаач миний бие 2017 оны намар Ховогсайрт буй гэрт нь очиж, том охин Н.Оюунбилигээс нь Н.Намжав дуучны намтар, дуулсан дуунуудынх нь талаар тэмдэглэн авч, хээрийн шинжилгээ хийсэн болно.

Нэг. Торгууд ардын дуучин Н.Намжавын товч намтар

Н.Намжав нь Шинжааны Ховогсайр Монгол Өөртөө Засах Сумын хуучин торгуудын зургаан багийн хүн. 1954 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Ховогсайр сумын Цагаанхөл багийн Буйлан хэмээх газар ард Намжаагийн хөвүүн болон мэндэлжээ. Н.Намжав бага наснаасаа аав Намжаагийн нөлөөгөөр монгол уртын дуунд сонирхолтой болж, монгол уртын дууны үг, аяыг өвлөн авчээ. Н.Намжав 1976 оны 9 дүгээр сараас эхлэн Цагаанхөл багт дуу хөгжмийн багшаар багшилж байв. Ийнхүү багшилж байхдаа ардын дуугаа орхилгүй хурим, найр наадамд уртын дуугаараа ая дуу өргөж, нэн олон хүний сонорт монгол уртын дууны эгшгээ уламжлуулж явсан шилдэг ардын дуучин, монгол уртын дууны гавьяатан билээ. Н.Намжав нь багшаар 25 жил ажиллахдаа намын шилдэг гишүүнээр өргөмжлөгдөж, мөн сургуулийн намын үүрийн даргын албыг он удаан жил хашжээ.

Н.Намжав 1989 онд Бээжин хотод болсон “*Монгол баатарлаг тууль “Жангарын тууль”-ийн өсгөлүүн*”-д уригдаж, уртын дуугаа дуулжээ. Мөн 1993 онд Монгол улсад болсон “*Дэлхийн уртын дууны наадам*”-д оролцож, “Нарийн сайхан хээр” дууг дуулж, алтан медаль хүртсэн байна. Тэр Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орны утга урлагийн холбоот нийгэмлэгийн гишүүн, БНХАУ-ын Залуучуудын нийгэмлэгийн гишүүн зэрэг үүрэгт ажлуудыг хийж гүйцэтгэж байжээ. Харамсалтай нь Н.Намжав 2001 оны 10 дугаар сард зуурдаар нас эцэслэсэн юм.

Түүний дуулсан “*Хан уулын орой*”, “*Улаан мэйрэнгийн ус*”, “*Алиа цавьдар морь*”, “*Төөлтэй сайхан хар*”, “*Харгай дүнгээн алим*” зэрэг дуу өнөөг хүртэл Ховогсайрын торгуудуудын дунд уламжлагдан дуулагдаж, найр наадам, хурим гийчийн гол дуу болон дуулагдсаар байна.

Хоёр. Н.Намжавын дуулсан дуунд буй морины зүсэм, тэдгээрийн бэлгэдлийг тайлбарлах нь

Дуу нь шүлэг, хөгжим хосолсон тул ард олны хамгийн дуртай урлагийн нэг хэлбэр болж газар болгонд маш өргөн дэлгэрчээ. “Монгол ардын дуу бол яруу сайхан хэллэгтэй, айзам цохилго бүхий уран сайхан шүлэг байхын зэрэгцээ хүмүүсийн дурыг болон сэтгэлийг хөдөлгөж чадахуйц чихний чимэг болсон хөг аялгуутай билээ. Урт удаан түүхэн явцад Ховогсайр ардын дуу ч гэсэн уламжлагдан хөгжиж, төлөвийн тогтохдоо үндэстний ба нутаг усныхаа өвөрмөц онцлогийг хадгалсаар ирсэн бөгөөд ах дүү үндэстний аж ахуй соёлын солилцоогоор дамжин тасралтгүй баяжин хөгжсөөр ирсэн байна” (Ринчендорж, 1981:8). Ховогсайрын торгууд ардын дуучин Н.Намжавын дуулсан дуунуудын шүлэг аялгуунаас монгол нутгийн дөрвөн улирлын байгалийн үзэмж тодорч, сүрлэг агаад утга уянга бүхий магтаалын онцлог шинж нь маш өвөрмөц байдаг юм.

Аман билгийн төрөл зүйлсийн гүн утга учрыг нээхэд чухал түлхүүр болох зүйлсийн нэг нь монголчуудын хувьд яах аргагүй адууны зүсэм билээ. “Газар нутаг, идэш тэжээл, цаг агаарын онцлогоос үүдэн дэлхий дахины адуун сүрэг олон зүсэмтэй болж өнөөг хүрчээ. Адууг өсгөн үржүүлэхийн зэрэгцээ нэрлэх, зүслэх, уналга эдэлгээнд сургах, тоног хэрэгсэл бэлтгэх гээд бүхэл бүтэн арга технологи, зан заншил түүхийн урт хугацааг туулан боловсорч, аж амьдрал, соёл, гоо зүйн бие даасан салбар болон хөгжжээ” (Мөнхтөр, 2002:8). Н.Намжавын дуулсан дуунд гүн гүнзгий утга агуулгатай дуу маш олон байдаг. Бид түүний дуунуудаас утга агуулгыг тодотгохын тулд морины зүсэм ашигласан гурван дууг онцолж, бэлгэдэл зүйн талаас тайлбарлахыг зорьсон билээ.

1. Ховогсайрын торгууд ардын дуучин Н.Намжавын дуулсан “Алиа цавьдар морь” нь гурван бадаг, 12 шад бүхий дуу юм.

“Алиа цавьдар морь

Аргамжаа эргэж мордоно

Ааль сайтай та нартайгаа

Ашдын хамт жаргалаа би” (Зоригт, 2004:217)

хэмээн дуулах бөгөөд найрынгийчид буян заяагаар учирсан хүндэт олонтойгоо ашдын хамт жаргахын бэлгэ ерөөлийг хүсэж дуулсан байна. Дууны нэр болон дуунд өгүүлэгдэж буй энэхүү “цавьдар” зүсмийн морь нь “Байх биед нь цайвар зээрд ноос ургасан бөгөөд дэл сүүл нь цэгээн шиг байж, цавь сүүл нь цагаавтар морь” (Намжил, 2010:65)-ийг хэлдэг. Мөн энэхүү цавьдар зүсмийн тухай нэгэн сонирхолтой тайлбар гарсан нь “Цавьдар гэдэг нь дэлийн өнгийг хэлнэ. Цайвар дэлтэй морийг ингэж нэрлэдэг” гэж зан үйлийн судлаач В.Сарангэрэл тайлбарлав. Тэгвэл “Алиа цавьдар гэсэн үг нь зан авирыг нь тодотгож нэрлэсэн байна. Энэ нь эрх чөлөөтэй, соргог дэгжин гэсэн зан төлөвийг тодорхойлсон. Цавьдар гэдэг зүсийг язгуураас нь авч үзэхэд цагаан өнгөтэй холбоотой. Цавь доороо цагаан, хар цагаан холилдсон өнгийг хэлж байна. Цагаан өнгийн суурьтай зүсэм. Цавьдар өнгөтэй холбоотой бэлгэдэл зүйн утга одоогоор илрээгүй учраас цагаан өнгөний бэлгэдэлтэй холбож үзнэ” хэмээн судлаач К.Цэрэндорж өгүүлсэн юм. Үүнээс үзэхэд цавьдар өнгө нь ганцхан өнгө биш, давхар өнгө гэсэн утгыг илэрхийлж байна. Зүсмийн бэлгэдэл заасан бүтээлүүдэд цавьдар өнгөний талаар дурдаагүй

тул хоёр дахь тайлбарт тулгуурлан энэхүү зүсмийн гол өнгө болох цагаан зүсэм нь “Тайван тогтуун аз жаргалант амьдралыг зөгнөх нэгэн зүйл санаа” (Дулам, 2020:71) бөгөөд энэ тайлбар нь дууны утга агуулгатай нийцэж байна.

Хоёрдугаар шадад “*Аргамжаа эргэж мордоно*” хэмээн тухайн мориныхоо ааль зан, үйлдлийг нь тодорхойлж, нөгөөтээгүүр, “Алиа цавьдар” гэсэн тодотголоо баталгаажуулж, найрт ирж байгаа үйлийг дүрсэлж байна. Ингэснээр тус хоёр шад нь тухайн морины зан ааш болон үйл хөдлөлийг тодорхойлон гаргаж, цаашлаад хүний сэтгэл мэдрэмжийн тогтож ядсан, дэнсэлж догдолсон төлөв байдлыг илтгэж байна.

Дараагийн шадад нь “*Ааль сайтай та нартайгаа*” хэмээн хүмүүст хандаж, найрлаж буйг, улмаар “*Ашдын хамт жаргана*” гэж найрын дууны онцлог болох ерөөл бэлгэдлийн санааг илэрхийлж байна. Ийм маягаар гурван бадгийнхаа төгсгөлд энэхүү үгээр ерөөн дуусгажээ.

Бумба тамгатай буурлыг

Бураан мөчрөөр тэжээлээ би

Буянаар учирсан та нартайгаа

Ашдын хамт жаргалаа би (Зоригт, 2004:217)

гэж хоёрдугаар бадагт дуулна. Эхний шадад “Бумба тамгатай буурлыг” хэмээн эхлэх бөгөөд бумба гэдэг үг нь “Найман тахилын гуравдугаарт ордог алт, мөнгө, зэс, гууль тэргүүтнээр хийсэн рашаан агуулах өндөр хүзүүтэй, бариулгүй сав”¹ юм. “Бумба тамга” гэж бумбаны хэлбэр дүрс бүхий тамгыг нэрлэнэ. Бумба тамганы бэлгэдэл нь рашааны хумх тоссон мэт хишиг буян дүүрэн (Дулам, 2011:98) байхад оршдог. Мөн бумба нь эрдэнийн зүйлээр хийгдэж, эрдэнэт зүйлийг агуулдаг гэсэн утгаараа баяжуулах, хүсэл бүхнийг биелүүлэхийг бэлгэддэг болой. Энэхүү тамга нь “Жангарын туульд гардаг. Дайснаа дарж ирснийхээ дараа дарж ирсэн дайсныхаа баруун хацарт бумбат улаан тамгаараа тамгалдаг. Мөн мал сүргийнхээ баруун гуянд бумбын алтан тамга дардаг үзэгдэл их гардаг. Бумбын алтан тамга нь Жангарын төрийн тамга” гэж судлаач К.Цэрэндорж өгүүлсэн юм.

“*Бумба тамгатай буурлыгаа*” хэмээн буурал морины зүсмээр энэ бадаг эхэлж байна. Тэгвэл “Буурал зүсмийн морьдын тухай дуу нь хаан төрийн ёс, зарлиг захиа, хишиг соёрхол тэргүүтнийг дурдсан” (2007:117) хэмээн эрдэмтэн С.Дулам тайлбарласан байдаг. Тэгвэл энэхүү уртын дуунд “*Бураан мөчрөөр тэжээлээ би*” гэж дараа шадад үргэлжлүүлсэн нь энэхүү буурал морио тусгайлан бэлдэж, таргалуулж, улмаар тэр тарган цатгалан морины буян хишгийг бэлгэдсэн бол, “*Буянаар учирсан та нартайгаа*” хэмээн үргэлжлүүлэхдээ хуримд ирсэн хүмүүсийг “буянаар учирсан” хэмээн тодотгожээ. Буян гэдэг нь буддын шашинд “Эх болсон зургаан зүйл хамаг амьтныг үрийн үрд амгалан байлгахын төлөө бүтээсэн сайн үйл”²-ийг хэлэх бөгөөд бэлгэдлийн утгаараа сайны хувь ерөөл, аз завшаан гэсэн санааг агуулдаг тул сайн ерөөл, сайхан завшаанаар учран танилцсан гэсэн санааг тодотгон дуулжээ. Үүнийг бататгаваас, халхын “*Хурдан буурлын тарган*” хэмээх “хаан дээдсийн хайр хишиг хүртэх хувь зохиолоо магтсан” (Дулам, 2020:122) дууны утга агуулгатай болон “буурал морины тарга, хүч”-ийг онцолсноороо тун төстэй байна.

¹ Монгол хэлний их тайлбар толь. www.mongoltoli.mn

² Монгол хэлний их тайлбар толь. www.mongoltoli.mn

Эдгээрээс харахад буурал зүсэм нь хаан төрийн хишгийг бэлгэдэж байгаа бол бумбат тамга нь мөн адил хаан төрийг бэлгэдэж байгаа тул энэ бадагт төрт ёс, шашны нөлөө орсон буюу буян ерөөлийг онцлон илэрхийлж, нийтэд хамаатуулан дуулжээ.

Хүрд тамгатай хүрнийг

Хүрэн баганаас хантарлаа би.

Хүндэт олон та нартайгаа

Ашдын хамт жаргалаа би (Зоригт, 2014:217)

хэмээн дууны гуравдугаар бадагт дуулдаг.

Хүрэн зүсэм нь “Монгол ардын бусад уртын дуутай жишиж үзвэл алс хол аян замын хүлэг унаа гэсэн нэгэн санаа тодрон гарч ирнэ” (Дулам, 2007:96) хэмээн тайлбарласны дагуу энэхүү дуунд мөн адил илэрч байна. Эдгээр нь тухайн зүсмийн морийг найр хуримд унах зорилгоор тусгайлан бэлтгэж, цаашлаад баяр ёслолыг хүндэтгэн дээдлэх утга агуулжээ. Харин хүрд тамга нь “Бул, хигээс мөөрийг нийлүүлэх дүгрэг болгож тэнхлэгт хэлхэж өнхрөн эргэхийг, бас эрт цагийн зэвсгийн нэр, шүтэх хүйс, таслах хигээс, хураамжлах мөөрийг бүртгэн хийчихүй гэхчлэн тайлсан байдаг” (Дулам, 2011:69) хэмээн дүрсний бэлгэдэл зүйд тайлбарлажээ. Энэхүү хүрд тамга нь хотол төгс, бүрэн бүтэн байдлыг бэлгэддэг. Мөн “Хүрд нь буддын шашны найман тахил эрдэнийн нэг. Загарвардийн хааны зэвсэг бөгөөд хандсан зүгтээ дайсангүй болдог гэж үздэг” хэмээн Хөх хотын Бурхан шашны сургуулийн судлаач Сумъяа тайлбарласан юм.

Гуравдугаар шадад буй “Хүрэн багана” гэсэн үг нь Ховогсайрын торгуудууд сүм хийдийг “хүрээ” гэж нэрлэдэг бөгөөд хүрэн багана буюу сүмийн гадна талд байгаа морь уядаг шонг хэлж байна. “Хүрээний баганаас хантарлаа” гэдэг нь сүмийн гадна буй уяаны шонд морио бэхлэн уялаа гэсэн санаа юм. Улмаар “Хүндэт олон та нартайгаа” хэмээн хүндэтгэн эрхэмлэх утгыг агуулжээ. “Алиа цавьдар морь” дуунд морины зүсэм, тамганы дүрсээр дамжуулж дууны утга санааг тодруулан илэрхийлж, онцлог шинжээ хадгалан уламжилжээ. Ингэхдээ гурван бадаг бүр өөр өөр хэлбэрээр, өөр өөр утга агуулсан байна. Морины зүсэм болоод бусад тайлбараас харахад, нэгдүгээр бадагт морь болоод хүний зан ааль, төлөв байдлыг зүсэм болон тэмдэг нэрээр тодотгосон бол, хоёрдугаар бадагт төр ёсны бэлгэдлийг чухалчилж буурал зүс, бумба тамгыг зэрэгцүүлж, гуравдугаар бадагт шашны хам сэдэвтэй холбогдон хүрд тамга, хүрээний багана зэрэг бурхны шашны бэлгэдлийг онцгойлжээ. Ийнхүү гурван өөр адууны зүсмээр дууны санаагаа баяжуулж, хотол олноороо цэнгэн жаргахыг бэлгэдэн ерөөсөн байна.

2. Ховогсайрын уртын дуучин Н.Намжавын дуулсан “Галзан хоо”³ нэртэй дуу бий. Энэхүү дуу нь:

“Галзан хоогоо унахаар

Газрын бараа харагдана

Газар усаа санахаар

Галзуу зүрх минь догдолно.

Хоо галзнаа унахаар

Холын бараа харагдана

Хошуу нутгаа санахаар

³ Галзан хоо- Халзан ухаа адууны зүс

Хоол шүлс минь зангирна.

Хадан дээрээ гарахаар

Хатирах санаа орно

Ханцуй тохой элэгдтэл

Хайрт ээж минь санагдана” (Зоригт, 2004:251)

гэж дуулдаг. Уг дууны нэрэнд буй “галзан [халзан]” хэмээх үг нь адуу малын зүсмийг тодорхойлдог. Энэ нь магнайгаасаа хамар хүртэл буюу дээрх уруул хүртлээ цагаан ноостой (Намжил, 2010:67) малыг нэрлэдэг. Харин “хоо [ухаа]” гэдэг үг нь мөн зүс заасан нэр бөгөөд ухаа зүсмийг Монголын Нууц Товчоон болон аман зохиолын бусад сурвалжид “хоа” (qoa) хэмээдэг. Хоо зүсэм нь “Байх биед нь цайвар шаргал ноос ургасан морийг хэлдэг. Уг өнгөний байдлыг дагуулж “хоо морь”, “хоогч гүү” гэж хэлэх тохиол байдаг бөгөөд “хоо галзан”, “галзан хоо” гэх мэтээр хэлэгдэх тохиол ч байдаг” (Намжил, 2010:67-68).

Уг дуу нь гурван бадаг, 12 шадаас бүрдэнэ. Эхний бадагт “Галзан хоо” гэж бичсэн бол дараагийн бадагт нь “Хоо галзан” гэж солбиж бичжээ. Үгсийн байр солигдсон ч утга хэвээрээ байна. Галзан хоо морио унахаар ус нутагтаа очмоор санагдаж, алс холыг зорих хүсэл нь бадарна. Тэгэхээр хоо галзан зүсэм нь мөн л холын явдалт морийг бэлгэдэж байна. Нутаг усаа санасан тэр их сэтгэлийн хөгийг “Галзуу зүрх догдолно”, “Хоолой шүлс зангирна” хэмээн туйлын байдлаар илэрхийлжээ. Харин сүүлийн бадагтаа “Хадан дээр гарахаар Хатирах санаа орно” хэмээн нутгаа санаж үгүйлсэн тэр мэдрэмж нь улам давамгайлж, хүнд хэцүү үедээ хүн ээжийгээ илүү санадаг, мөн уул хаданд мориор явахдаа маш болгоомжилж явах байтал хатирч явахыг санаж хүсэх нь болохгүй, боломжгүй зүйлийг ч болгох, чадах мэт санах буюу хэрээс хэтэрсэн санааг илэрхийлж байна. Улмаар “Ханцуй тохой элэгдтэл Хайрт ээж минь санагдана” хэмээсэн нь нэг талаараа нутаг орноо монголчууд эх хүнтэй зүйрлэдэг тул ихэсгэлийн аргаар ханцуй тохой элэгдтэл уйлж гансарснаар дүрсэлжээ. Нөгөөтгээгүүр, эх нутгаа санасан хүн гэр орноо, ээж ааваа санах нь дамжиггүй гэсэн утгаар шууд “ээж” хүнийг онцолсон байж болох юм. Ийнхүү хоо галзан, галзан хоо морь нь энэ дуунд дэд дүр болж, ээж нутаг хоёроо санагалзаж буй уянгын баатрын сэтгэлийн илэрхийлэмжийг тод томруунаар гаргажээ.

3. “Нарийн сайхан хээр” хэмээх дуу нь олон хувилбартай бөгөөд энд бидний авч үзэж буй Ховогсайрын дуучин Н.Намжавын дуулсан “Нарийхан сайхан хээр” дуунд:

“Нарийхан сайхан хээрийгээ

Арслан тавлаж уналаа би

Найдамгай зантай чамдаа

Наадмаа хэлж суулаа би” (Зоригт, 2004:253)

гэхчлэн дуулдаг.

Уг дуунд гарч буй хээр зүсмийн морь нь байх биед улаавтар ноос ургасан морийг хэлэх (Намжил, 2013:63) бөгөөд “Ерийн ард олны өдөр тутмын мал ахуй, ан гөрөө, амраг янагийн болзоондоо унадаг эгэл энгийн утга бэлгэдэлтэй зүсэм болов уу хэмээн сэтгэгдэнэ” (Дулам, 2007:94). Алс хол байгаа амрагтаа очихын тулд холын унаа болох хээр зүсмийн морь, улмаар зүс нь “нарийн сайхан” хэмээн тодотгосон нь амраг хайртай хүндээ аль гоё сайхныг унаж очдог

хүндлэлт сэтгэлгээтэй холбогдож байна. Энэхүү дуу нь дөрвөн бадаг, 16 шадтай. Эхний бадагт буй “Архлан тавлаж уналаа би” гэсэн шадад байгаа “архлах” хэмээх үг нь малыг уяж идүүлэх үйлийн нэр бөгөөд “тавлах” гэдэг үг нь сойн унах санааг илтгэнэ. Ийнхүү тухайн морио аргамжин унаж байгаа нь хайрлан гамнаж буйг илтгэнэ. “Найдамгай зантай чамдаа Наадмаа хэлж суулаа би” гэж амраг хайртаа энхрийлэн дуулж байна.

Цэл шар говьд

Цэргийн чинь агт шаргина

Цэлгэр хурц наранд

Чиний чинь царай бүрэлзэнэ (Зоригт, 2004:253)

хэмээн хоёрдугаар бадагт дуулна. Энэ бадагт морины зүсэм тодорхойлохоос илүү дууны эзнийг тодотгож, цэрэгт очсон, агт шаргих буюу очоод олон адуу хариулж буйгаар дүрсэлжээ. Говийн хурц наранд хэмээн баатрыг хаана алба хааж буйг нь илэрхийлсэн байна. Мөн хаана ч явсан хайртай хүнээ санан үгүйлж байгааг сүүлийн шадад илэрхийлжээ.

Хүрээд ирэх газарт

Хүрэнгийн чинь хөлс хайртай юу

Хүүндээд суумаар газарт

Чиний чинь сэтгэл хуумгай юу (Зоригт, 2004:253)

хэмээн гуравдугаар бадагт дуулна. “Хүрээд ирэх газарт хүрэнгийн чинь хөлс хайртай юу” гэж эхэлж буй нь хүрэн зүсмийн бэлгэдэлтэй холбогдож байна. Хүрэн зүсэм нь дээр өгүүлсэнчлэн холын явдал, янаг амрагийн бэлгэдлийг агуулдаг. “Хөлс хайртай юу” гэсэн нь морио гамнан хайрлаж ирэв үү гэсэн санааг илэрхийлж, улмаар “Хүүндээд [ярьж хөөрөлдөөд] суумаар газарт Чиний чинь сэтгэл хуумгай юу” гэж өөрт хамаатуулан, хайрын сэтгэл нь хувирсан үгүйг лавлаж байна.

Хатираад ирэх газар

Харын чинь хөлс хайртай юу

Харгалдаад суумаар газарт

Чиний чинь сэтгэл хуумгай юу (Зоригт, 2004:253)

гэж дөрөвдүгээр бадагт дуулах бөгөөд “Хатираад ирэх газарт Харын чинь хөлс хайртай юу” хэмээн хар зүсмийн морийг гаргажээ. Хар морь нь “Язгуур уламжлалт төр ёс, зан заншил, төрийн алба, түүнд зүтгэгсдийн үйл хэрэг, сургаал ном, аж зуулга, санаа сэтгэлийг илтгэх илтгэц нь гэж хэлж болно” (Дулам, 2007:85). Харгалдаад суумаар газар гэсэн нь уулзаж учирмаар гэсэн утгатай юм. Мөн л сэтгэлийн байдал хөнгөн хуумгай эсэхийг дахин лавлажээ. Ийнхүү энэ дуунд хээр, хар, хүрэн гэсэн гурван зүсмийн морь гарч байгаа ч дууны нэр болоод эхлэл бадагт гарч буй “Нарийн сайхан хээр” мориор хар болон хүрэн зүсмийн морио илүү тодотгож, санаагаа лавшруулжээ.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлдээ Шинжааны Ховогсайр Монгол Өөртөө Засах Сумын торгууд ардын дуучин Намжаагийн Намжавын намтар, уран бүтээлийн талаар товч өгүүлж, морины зүсмийг онцолсон “Алиа цавьдар морь”, “Галзан хоо”, “Нарийхан сайхан хээр” гэсэн гурван дууг онцлон авч, бэлгэдэл зүйн талаас нь задлан шинжиллээ.

1. “*Алиа цавьдар морь*” дуунд хүн зоны ааль, төлвийг морины цагаан цавьдар зүсмээр бэлгэдэн тодотгосон бол, буурал зүс, бумба тамгаар төр ёсыг бэлгэдэж, мөн хүрд тамга, хүрээний багана зэргээр шашны хам сэдэвтэй холбогдон, хотол олноороо төр-шашнаа хослуулан, цэнгэн жаргахыг бэлгэдэн ерөөсөн утга санааг илэрхийлжээ.

2. “*Галзан хоо*” дуунд хоо галзан, галзан хоо мориор бэлгэдэл дүр бүтээж, ээж, нутаг хоёроо санаж буй хүний сэтгэлийг тод томруунаар дүрсэлсэн байна.

3. Харин “*Нарийхан сайхан хээр*” янаг амрагийн дуунд хээр, хар, хүрэн гэсэн гурван зүсмийн морины бэлгэдлээр алс холоос хайртай хүнээ санаж үгүйлэх сэтгэлийг илтгэсэн байна. Эдгээрээс харахад, Ховогсайрын торгуудуудын дунд өргөн тархсан энэхүү гурван дууны утга агуулгыг шинжлэн судлахад морины зүсмийн бэлгэдэл нь дууны утга санааг улам гүнзгийрүүлэх чухал үүрэг гүйцэтгэжээ.

Ном зүй

Бат, Д., Дангажав, Л. (2018). Баруун монгол ардын дууны уламжлал ба түүх соёлын хувьсал.

Бээжин: Бээжингийн Үндэстний Хэвлэлийн Хороо.

Дулам, С. (2007). Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй. Монгол бэлгэдэл зүй. II боть.

Улаанбаатар: Битпресс ХХК.

Зоригт, Н. (2004). Ховогсайр монгол ардын аман зохиолын дээж. Үрүмч: Шинжааны Ардын Хэвлэлийн Хороо

Мөнхтөр, Л. (2002). Монгол адуу (морь)-ны зүс, шинж заасан үгсийн утга зүй, бүтэц (Ардын аман зохиолын жишээн дээр). Улаанбаатар: Тоонот принт.

Намжил, Д. (2010). Ойрад монголын зан үйлийн соёл: Ахуй амьдралын боть. Үрүмч: Шинжааны Ардын Хэвлэлийн Хороо.

Ринчендорж. (1981). Монгол ардын мянган дуу. Хөх хот: Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо.

Эрдэй, О. (2004). *Тив алсан зүүнд буцсан торгуудчууд*. Үрүмч: Шинжааны Ардын Хэвлэлийн Хороо.

Abstract

In this article I have analyzed three long songs “Alia tsavidar morin”, “Galzan Hoo”, “Nariihan saikhan kheer” of Hovogsair’s *torguts*. In long songs related to Mongolian horses, the colors of those horses are symbolized and various meanings are expressed. Namjav Namjaa is a unique singer who was born among the Torgut people of Hovogsair, Xinjiang, and his long songs are still sung at weddings. Among the songs Namjav sings, three songs are about the color of horses, and we have analyzed these three songs. The characters of the horse and the color of the horse and in the long song of Hovogsair’s *Torguts* conveys important and deeply ideas In the song “Alia tsavidar mori”, the state is symbolized by “buural” color and buddizm is symbolized by “bumba (cupping glass)” stamp. He also song a song combining the state and religion, symbolizing religion with the “khüрд (wheel)” stamp and the monastery. In general, this song symbolizes peace for all. Also in the song “Galzan hoo”, the Hoo galzan and Galzan hoo horses are used as symbolic characters, clearly expressing the feelings of a person who misses his mother and country. In the song of the third song, “Nariikhan saikhan kheer”, the lover’s song shows the feeling of longing for a loved one who is sitting far away with the symbol of three horse colors: “kheer”, “khar” and “khüren”. These songs are symbolized pease for all.

Keywords: Long song, horse color, symbols, Hovogsair’s *torguts*, singer Namjav Namjaa